

MNS 6653:2017 стандартад оруулах өөрчлөлт

1. Стандартын 1 дүгээр хүснэгтийн үнэлгээ хэсгийг MNS GOST 52522:2010, Хүнсний зориулалттай түүхий эдээс гарган авсан этилийн спирт, архи, ликёрын төрлийн бүтээгдэхүүнд мэдрэхүйн шинжилгээ хийх арга стандарттай уялдуулан

1-р хүснэгт – Шимийн архины мэдрэхүйн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Нэмэлтгүй	Үнэлгээ, балл
1	Үнэр	Исгэлэн сүүний үл мэдэг үнэртэй. Гадны үнэргүй	11-14
2	Амт	Исэг цагаан идээний өвөрмөц амттай. Гадны амтгүй	12-14
3	Өнгө	Тунгалаг, сүүний уургийн болон тосны тунадасгүй	3-4
4	Биет байдал	Шингэн, тунадасгүй, гадны хольцгүй	6-8
Нийт дүн			32-40

гэснийг

Д/д	Үзүүлэлт	Шаардлага	Үнэлгээ
1	Үнэр	Исгэлэн сүүний үл мэдэг үнэртэй. Гадны үнэргүй.	3,0-4,0
2	Амт	Исэг цагаан идээний өвөрмөц амттай. Гадны амтгүй.	3,0-4,0
3	Гадаад байдал	Тунгалаг, шингэн, сүүний уургийн болон тосны тунадасгүй, гадны хольцгүй	1,5-2,0
Нийт			7,5-10,0

гэж өөрчлөх

2. 2 дугаар хүснэгт - Шимийн архины физик-химийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт, хэмжих нэгж	Шаардлага
1	Этилийн спиртийн хэмжээ, хувиар (эээлхүүний)	6-15
2	Исгэлэн, T ^o , ихгүй	25
3	Сувсны тос (1 л усгүй спиртэд шилжүүлэн тооцсон), мг/л, ихгүй	130,0
4	Альдегид (1 л усгүй спиртэд шилжүүлэн тооцсон), мг/л, ихгүй	15,0
5	Метилийн спирт (усгүй спиртэд шилжүүлэн тооцсон) хувиар, ихгүй	0,001

гэснийг

Д/д	Үзүүлэлт, хэмжих нэгж	Шаардлага	Үндэслэл
1	Этилийн спиртийн хэмжээ, хувиар (эээлхүүний)	6-18	Шинэ нэр төрлийн шимийн архи үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх
2	Хүчиллэг, г/л, ихгүй	3,0	"MNS 2117 :1989, Төрөл бүрийн архи. Шинжлэх арга" стандартын дагуу исгэлтийн бүтээгдэхүүний хүчиллэгийг сүүний хүчилд шилжүүлэн тооцож, г/л-ээр илэрхийлэх нь зүйтэй гэж үзэж байна.
3	Сувсны тос (1 л усгүй спиртэд шилжүүлэн тооцсон), мг/л, ихгүй	-	1. Бусад улсын уламжлалт, ижил төстэй исгэлтийн бүтээгдэхүүнд тухайлбал, sake (Япон), сүүн архи (Хятад) зэрэг харьцуулахад альдегид, сувсны тосны агууламжийг тухайн бүтээгдэхүүний стандартад тодорхой хязгаар зааж стандарчилдаггүй байна. Солонгос улсын Сөжү архинд альдегидийн хэмжээг 700 мг/л байхаар заасан байна.
4	Альдегид (1 л усгүй спиртэд шилжүүлэн тооцсон), мг/л, ихгүй	-	2. Мөн дэлхийд танигдсан брэнд бүтээгдэхүүн болох виски, коньяк, самогон зэрэг бүтээгдэхүүнд альдегидын хэмжээг 10-350мл/л, сувсны тосны хэмжээг 500-6000мг/л гэж маш өндөрөөр заасан байдаг байна. Шимийн архины хувьд үндсэн түүхий

			<p>эд болох сүүний өөрийн онцлог чанар, шимт бодисын найрлагаас хамаарч исгэх, нэрэх явцад үүсэх альдегид, сувсны тос нь бүтээгдэхүүнд онцгой өвөрмөц, амт, үнэр өгдөг ба хүний биед сөрөг нөлөө багатай байдагтай холбоотой учир тодорхой хязгаар заах шаардлагагүй гэж үзэж байна.</p> <p>3. Манай улсад урьд нь мөрдөж байсан "Төрөл бүрийн дарс, дарсны төрлийн бүтээгдэхүүн. Техникийн шаардлага MNS 5074 :2001" стандартад Шимийн архины физик химийн үзүүлэлтийг этилийн спирт, хуурай бодис, хүчиллэг, дэгдэмхий хүчиллэгийн агууламжаар тогтоосон байсан билээ. Энэхүү стандартыг Хүнсний салбарт олон жил ажилласан, туршлагатай эрдэмтэн доктор П.Цэвэгмэд, П.Одонмажиг нар боловсруулан батлуулж оруулж байсан нь тодорхой үндэслэлтэй болохыг харуулж байна.</p>
5	Метилийн спирт (усгүй спиртэд шилжүүлэн тооцсон) хувиар, ихгүй	0,003	<p>1. Монгол улсад мөрдөж буй исгэлтийн бүтээгдэхүүний стандартад тусгасан хамгийн бага утга</p> <p>2. Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 64 тоот тушаалаар баталсан "Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалт"-д импортоор оруулж буй согтууруулах ундаанд метилийн спиртийн зөвшөөрөгдөх хэмжээг 0.05-15.0 % гэж оруулсан байдаг.</p>

гэж өөрчлөх

3. Бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулахад маш нарийн шүүлтүүрээр шүүж байгаа тул хадгалах нөхцөл, хугацаанд өөрчлөлт орохгүй байгаа нь туршилтаар батлагдсан тул 7.2 Шимийн архийг үйлдвэрлэснээс хойш 4-12 °С температурт 1 жил хүртэл хадгална. гэснийг

7.2 Шимийн архийг үйлдвэрлэснээс хойш 0-25 °С температурт 2 жил хүртэл хугацаанд хадгална. гэж өөрчлөх

**Бусад улс орны согтууруулах ундааны үзүүлэлттэй
MNS 6653:2017 стандартын үзүүлэлтийг харьцуулсан судалгаа**

	БНХАУ-ын сүүний архи GB/T23546-2009	БНСУ-ын Сөжү архи	ОХУ-ын Коньяк ГОСТ 31732-2014	ОХУ-ын Виски ГОСТ 55315-2012	Виски Дорнод Африк DEAS 141-2013	Япон Сакей архи	ОХУ Самогон ГОСТ 56368-2015	Шимийн архи MNS 6653:2017
Этилийн спирт, % - багагүй	19-48	18-21	40	40	37.5	16	35-50	6-15
Метанол, % - ихгүй	0.01г/л	0.5мг/мл	2.0	0.1	2.0		0.05	0.001
Альдегид, мг/л	-	70 мг/100мл	50 мг/100мл	10-350 мг/л	400		10-350 мг/л	15
Сувсны тос, мг/л	-	-	500 мг/л	500-6000 мг/л			500-6000 мг/л	130
Нийлмэл эфир, мг/л	2.0г/л		270 мг/100мл	50-1500 мг/л			50-1500 мг/л	